

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2023.06.25


Зорилго: Байгууллага нь албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин болон ажлын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдынхаа сэтгэл ханамжийн судалгааг явууллаа.

Санал асуулгыг цахим хэлбэрээр асуулгыг бэлтгэж албан хаагч бүрт линкийг явуулж бөглүүлсэн. Санал асуулгад нийт ажилчдын 73.3 хувь нь буюу 22 албан хаагч оролцлоо. Асуулт бүрт сайн, дунд, муу гэсэн сонголттой үнэлгээг өгөхөөр төлөвлөсөн.

Санал асуулгыг нийт 9 асуумжаар авсан ба сонголттой асуумж 8, нээлттэй асуумж 1 байсан.


а. Санал асуулгын дүнг асуулт бүрээр нэгтгэн графикаар харуулж байна.

График 1.




Албан хаагчдын санал асуулгын дүнг асуумж бүрээр задалж графикаар харууллаа.

Асуулт 1. Та өөрийн ажилдаа хэр сэтгэл ханамжтай байна вэ? Гэсэн асуултанд нийт 22 албан хаагч оролцсон ба дунд гэсэн үнэлгээг 14%, сайн гэсэн үнэлгээг 86 хувь нь өгсөн байна.




Асуулт 2. **Та даргынхаа харилцаа хандлага, ёс зүйг хэрхэн үнэлж байна вэ?** гэсэн асуултанд нийт 22 оролцогчийн 77 хувь нь сайн, 18 хувь нь дунд, 5 хувь нь муу гэж хариулсан байна.




Асуулт 3. **Ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны тохижилт таны сэтгэлд хэр нийцэж байна вэ?** гэсэн асуултанд нийт 22 оролцогчийн 86 хувь нь сайн, 14 нь дунд гэж хариулсан байна.

Ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны тохижилт таны сэтгэлд хэр нийцэж байна вэ?




Асуулт 4. Техник тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдал? гэсэн асуултанд нийт 22 албан хаагчийн 46 хувь нь сайн, 45 хувь дунд, 9 хувь муу гэж хариулсан байна.

Техник тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдал?




Асуулт 5. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цаг баримтлах байдалд үнэлгээ өгнө үү? гэсэн асуултанд нийт 22 албан хаагчийн 18 хувь нь муу, 27 хувь нь дунд, 55 хувь нь сайн гэж хариулсан байна.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цаг баримтлах байдалд үнэлгээ өгнө үү?




Асуулт 6. Ажлын байран дээрээ та өөрөө мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж байдаг уу? гэсэн асуултанд нийт 22 албан хаагчийн 55 хувь нь боломжтой, 36 хувь боломжгүй, 9 хувь нь ажлын ачаалаал их гэж хариулсан байна.

Ажлын байран дээрээ та өөрөө мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж байдаг уу?




Асуулт 7. Байгууллагын дотоод сургалтанд хэр ач холбогдол өгдөг вэ? гэсэн асуултанд нийт 22 албан хаагчийн 59 хувь нь сайн, 41 хувь нь дунд гэж хариулсан байна.

Байгууллагын дотоод сургалтанд хэр ач холбогдол өгдөг
вэ?



Асуулт 8 Албан хаагчдын ёс зүйн талаар хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултанд нийт 22 албан хаагчийн 59 хувь нь сайн, 36 хувь нь дунд, 5 хувь нь муу гэж хариулсан байна.

Албан хаагчдын ёс зүйн талаар хэрхэн үнэлж байна вэ?



Дүгнэлт:

Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийхэд нийт албан хаагчдын дийлэнх буюу 86 хувь нь өөрийн ажилдаа сэтгэл ханамжтай, 55 хувь нь ажлын байран дээрээ мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж байна гэж дүгнэсэн бол хамт олны ёс зүй, төлөвшил, цаг ашиглалтын хувьд нийт

оролцсон албан хаагчдын 45 хувь нь муу буюу дунд гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь нэг хамт олон болж нэгдээгүй бие биенээ үл хүндэтгэсэн, үзэл бодлын зөрүүтэй байдал байдаг, мөн ажиллах нөхцөл, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдалд 54 хувь нь муу буюу дунд гэж хариулсан нь ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны тохижилт хангалтгүй байгаа байдал харагдаж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр албан хаагчдад танилцуулах
2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, өрөө тасалгааны тохижилтод анхаарах
3. Ёс зүй харилцаа хандлага, цаг ашиглалтыг сайжруулах сургалтыг тогтмол явуулдаг байх.
4. Ажлын байран дээрээ мэдлэг боловролоо дээшлүүлэхэд боломж олгож байхад нь анхаарах.

Судалгааг нэгтгэсэн:
МТОНХА

Ч.Ундармаа

Танилцсан:
Засаг даргын Тамгын газрын дарга

П.Наранмандах

